



## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 23/Н

Улаанбаатар хот

### Нийтийн тээврийн үйлчилгээний салбарын санхүүжилтийн түр журам, зардлын тариф батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 /г/, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Нийтийн тээврийн үйлчилгээний салбарын санхүүжилтийн түр журам”-ыг нэгдүгээр, “Машин цагийн зардлын тариф”-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д ДААЛГАХ нь:

2.1. Улаанбаатар хот болон Датакарт концерциум хооронд 2014 онд байгуулсан “Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд удирдлага мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлэх төслийг хөгжүүлэх гэрээ”-г 2019 онд багтаан шинэчлэх;

2.2. Нийтийн тээврийн үйлчилгээний зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу сонгон шалгаруулж, үйлчилгээний орлого төвлөрүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах;

2.3. Нийтийн тээврийн үйлчилгээнд зөвхөн цахим картаар зорчих боломжийг бүрэн хангаж, иргэд зорчигчдод цахим төлбөрийн нэг удаагийн зорчилтын карт, явуулын карт цэнэглэх, борлуулах үйлчилгээ, цахим төлбөрийн карт цэнэглэх автомат машиныг үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх;

2.4. Нийтийн тээврийн үйлчилгээний Удирдлага мэдээллийн болон цахим төлбөрийн системийн тоног төхөөрөмж, хяналтын камерын хэвийн, бүрэн бүтэн байдлыг ханган ажиллаж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд 2019 онд багтаан танилцуулах;

2.5. Нийтийн тээврийн салбарын төвлөрсөн орлогыг харьяа албаныхаа дансанд төвлөрүүлж, хуваарилах боломжийг судалж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд 2019 оны эхний хагас жилд багтаан танилцуулах;

2.6. Нийтийн тээврийн үйлчилгээний орлогыг төвлөрүүлсэн дүнгээр нь нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад хуваарилж, шилжүүлэх ажлыг Нийтийн Тээврийн үйлчилгээний газраар дамжуулан зохион байгуулах;

1110100043

2.7. “Цахим төлбөрийн карт”-аар үйлчлүүлсэн зорчигч нийтийн тээврийн нэг хэрэгслээс нөгөөд 30 минутын дотор дамжин суулт хийхэд 1 удаа үнэ төлбөргүй зорчих бөгөөд ялгаатай тарифаар дамжин суулт хийх тохиолдолд зөрүү төлбөрийг зорчигч нь нэмж төлөн зорчихоор шийдвэрлэх, хот орчмын чиглэл бүрт нэгдсэн тарифыг мөрдүүлэх;

2.8. Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/809 дүгээр захирамжаар байгуулагдсан “Нийслэлийн нийтийн тээврийн зохицуулах зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, машин цагийн зардлын тарифын холбогдох задаргааг батлан, нийтийн тээврийн үйлчилгээний санхүүжилтийг шийдвэрлэж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д даалгасугай.

4. Машин цагийн зардлын тарифыг шинэчлэн баталсантай холбогдуулан 2019 оны нэгдүгээр улирлын машин цагийн зардлын зөрүүг тооцож олгохыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.


5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 6/22 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

6. Энэхүү тогтоолыг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдсүгэй.

ДАРГА



Р.ДАГВА



## НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН САНХҮҮЖИЛТИЙН ТҮР ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар, "Улаанбаатар смарт карт" ХХК, Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын хоорондын төлбөр тооцоог түргэн шуурхай явуулах, үйлчилгээний орлогыг нэгдсэн дансанд төвлөрүүлэх, хуваарилах, шугамын орлого бүрдүүлэлтэд хяналт тавих, нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүүг нийслэлийн төсөвт тусгах, нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.2.1. "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж" гэж Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газартай гэрээ байгуулан нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэж байгаа тээвэрлэгч этгээдийг;

1.2.2. "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний орлого" гэж цахим төлбөрийн хэрэгслээр төлсөн хөлсийг;

1.2.3. "Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем" (УМЦТС) гэж нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслүүдийг бүртгэл мэдээллийн GPS төхөөрөмж ашиглан өдөр тутам бүртгэн ажлын даалгавар, түүний гүйцэтгэл, зөрчлийн мэдээ, зорчигч урсгал, орлого төвлөрүүлэлт, хуваарилалт гэх мэт холбогдох мэдээ, тайлан гаргах нэгдсэн системийг;

1.2.4. "Машин цагийн зардал" гэж нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа автобус, троллейбус нэг цаг ажиллахад гарах зардлыг;

1.2.5. "Машин цагийн гүйцэтгэл" гэж нийтийн зорчигч тээврийн удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системээс Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрын баталсан ажлын даалгаврын дагуу гарсан өдөр, сар, жилээр нэгтгэсэн нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн ажилласан цаг, рейсийг;

1.2.6. "Нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүү" гэж машин цагийн зардлаас нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний орлогыг хассан дүнг;

1.2.7. "Нийтийн тээврийн үйлчилгээний зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавих байгууллага" гэж Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газартай гэрээ байгуулан нийтийн тээврийн үйлчилгээний хөлс төлөлтөд хяналт тавих эрх бүхий хөндлөнгийн этгээдийг;

### Хоёр. Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний орлогыг төвлөрүүлэх, хуваарилах

2.1. Нийтийн тээврийн үйлчилгээний орлого бүрдүүлэх, төвлөрүүлэх, нэмэгдүүлэх үйл ажиллагааг Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар, "Улаанбаатар смарт карт" ХХК, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд болон нийтийн тээврийн үйлчилгээний зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавих байгууллага нар хамтран зохион байгуулна.

2.2. Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар нь "Улаанбаатар смарт карт" ХХК-тай "Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэл хяналт, мэдээлэл,

төлбөр хураалтыг гүйцэтгүүлэх” гэрээг болон тухайн төсвийн жилийн санхүүжилтийн гэрээг, Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдтэй “Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх” гэрээг болон тухайн төсвийн жилийн санхүүжилтийн гэрээг, нийтийн тээврийн үйлчилгээний зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавих байгууллагатай “Нийтийн тээврийн үйлчилгээний орлого төвлөрүүлэх, нэмэгдүүлэх ажил гүйцэтгүүлэх” гэрээг болон тухайн төсвийн жилийн санхүүжилтийн гэрээг тус тус байгуулж, биелэлтийг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд “Улаанбаатар смарт карт” ХХК нь нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдтэй УМЦТС-ийн тоног төхөөрөмжийг суурилуулах ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулсан гэрээг байгуулж ажиллана.

2.3. Нийтийн тээврийн үйлчилгээний зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавих байгууллага нь энэ журмын 4.2-д заасан нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний орлогын доод хязгаарыг төвлөрүүлэх ба “Улаанбаатар смарт карт” ХХК болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд орлогын доод хязгаарыг төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

2.4. Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар нь “Улаанбаатар смарт карт” ХХК-иас ирүүлсэн мэдээг үндэслэн тухайн өдрийн нийтийн тээврийн үйлчилгээний орлогыг хуваарилан ажлын 2 өдөрт багтаан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

2.5. “Улаанбаатар смарт карт” ХХК, Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд нь төлбөр тооцооны цахим болон цаасан баримт, бусад холбогдох материалуудыг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж болгон хадгална.

#### Гурав. Төлбөр тооцооны үйл ажиллагаа

3.1. “Улаанбаатар Смарт Карт” ХХК нь нийтийн тээврийн үйлчилгээний орлого бүрдүүлэх, хуваарилах, төлбөр тооцоо гүйцэтгэхэд нийтийн тээврийн УМЦТС-ийн програм хангамж, тоног төхөөрөмжүүдийн ашиглан бодит цагийн горимоор найдвартай, тасралтгүй явуулах үйл ажиллагааг хариуцна.

3.2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь дээрх системийн үйл ажиллагааны найдвартай байдалд холбогдох мэргэжлийн газар, харьяа албаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажиллана.

3.3. Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар, “Улаанбаатар смарт карт” ХХК-иас ирүүлсэн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын өмнөх сарын ажлын гүйцэтгэлийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтэс хянан үзэж, Нийслэлийн тухайн төсвийн жилийн санхүүжилтийн гэрээний дагуу “нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүүг санхүүжүүлэх” зардлаас Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дансаар дамжуулан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад дараа сарын 12-ны өдрийн дотор санхүүжүүлнэ.

3.4. “Улаанбаатар смарт карт” ХХК нь нийтийн тээврийн үйлчилгээний мэдээг Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газраас гаргасан загварын дагуу өдөр бүр танилцуулж, тайланг сар, улирал, жилээр баталгаажуулж хүргүүлнэ.

#### Дөрөв. Нийтийн тээврийн үйлчилгээний зардлыг тооцоолох, нийслэлийн төсөвт тусгах

4.1. Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар нь нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүүд төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээг жилийн үйлчилгээний даалгавар цагийг нэг машин цагийн зардлаар үржүүлж, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний орлогын дүнг хасаж тооцоолж, нийслэлийн

төсөвт тусгуулах саналаа Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулна.

4.2. Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар нь “Улаанбаатар Смарт Карт” ХХК-ийн УМЦТС-ийн бүртгэл, тайланг үндэслэн чиглэл тус бүрийн орлогын доод хязгаарыг улирал тутам тогтоож, баталгаажуулна.

4.3. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь улирал, жилийн эцэст санхүүгийн байдлын тайлан, тээвэрлэлтийн нэгдсэн тайлан мэдээг, “Улаанбаатар смарт карт” ХХК нь цахим төлбөрийн карт борлуулалт, ашиглалтын мэдээг тогтоосон загварын дагуу тус тус үнэн зөв гаргаж Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газарт хүргүүлнэ.

4.4. Инфляцын төвшин, шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалан нэг машин цагийн зардалд өөрчлөлт орох тохиолдолд Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар нь холбогдох судалгаа, төсөвт тусгуулах саналаа Нийслэлийн Засаг даргаар дамжуулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлнэ.

4.5. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь энэ журмын дагуу хийгдэх бүхий л төлбөр тооцоо, мэдээлэл, судалгаанд хяналт тавьж ажиллана.

4.6. Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар нь шугамын орлогын бүрдүүлэлтийн талаарх мэдээллийг хагас жил тутамд Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд, сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст танилцуулж ажиллана.

#### Тав. Хариуцлага

5.1. “Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэх, гүйцэтгүүлэх гэрээ”-ний тухайн сарын дүгнэлтээр “хангалтгүй” үнэлгээтэй дүгнүүлсэн эсхүл дүгнүүлээгүй бол тухайн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүү санхүүжилтийг олгохгүй.


5.2. Нийтийн тээврийн үйлчилгээний зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавих байгууллага нь энэ журмын 2.3-д заасан нийтийн тээврийн үйлчилгээний орлого төвлөрүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд орлогын доод хязгаарт хүрээгүй үнийн дүнгийн зөрүүг тухайн байгууллагад олгогдох санхүүжилтээс хасаж олгоно.

5.3. “Улаанбаатар смарт карт” ХХК нь энэ журмын 2.3-д заасан үүргээ биелүүлээгүй, хангалттай хэрэгжүүлээгүй тохиолдолд холбогдох гэрээний дагуу олгогдох ажил, үйлчилгээ эрхэлсний шимтгэлээс 30 хүртэл хувиар хасаж олгоно.

5.4. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын “Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх” гэрээний үүргийн биелэлтийг харгалзаж олгогдох санхүүжилтээс 30 хүртэл хувиар хасаж олгоно.

5.5. Энэхүү журмын 5.2-5.4-т заасан хариуцлагын талаар журмын 2.2-т заасан гэрээнд тусгана.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн  
23/14 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



### МАШИН ЦАГИЙН ЗАРДЛЫН ТАРИФ

Д/д	Тээврийн хэрэгслийн төрөл	Нэг машин цагийн зардал /төгрөг/
1	Угсраа автобус	54,978
2	Их багтаамжийн автобус	37,789
3	Троллейбус	32,468
4	Дунд багтаамжийн автобус	34,259

---o0o---